



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/204

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 14.5.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1, 2.1.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн аварга шалгаруулах хийн дасгалын уралдаанд оролцох ахмадуудын унааны зардалд 215,400 (хоёр зуун арван таван мянга дөрвөн зуу) төгрөг, Шавар түрүү, Тээлийн голд үерт орсон авто машинуудад тусламж үзүүлэх ажлаар явсан шатахууны зардалд 448,800 (дөрвөн зуун дөчин найман мянга найман зуу) төгрөг, бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлын шатахууны зардалд 477,840 (дөрвөн зуун далан долоон мянга найман зуун дөч) төгрөг, нийт 1,142,040 (нэг сая нэг зуун дөчин хоёр мянга дөч) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2.Зардалд шаардагдах 1,142,040 (нэг сая нэг зуун дөчин хоёр мянга дөч) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН